



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/510

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 3 дугаар хавсралтын 4.19 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Гурван сэнхэр төвтэй таван од" аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аялал жуулчлалын 21 компаниас туршлага солилцох, зөвлөх үйлчилгээ авах ажилд зориулан 19 000 000 төгрөг /арван есөн сая/-ийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Л.Батбаяр/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.

3. Дээрхи төсөл, арга хэмжээг Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.19-д тусгагдсан "Гурван сэнхэр төвтэй таван од" аялал жуулчлалын хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 2070

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 27-ны өдрийн
А/510 дугаар захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КОМПАНИУДЫН
ХОВД АЙМГИЙН ТҮҮХЭН ДУРСГАЛТ, БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗРУУДАЙ
ТАНИЛЦАХ 1300 КИЛОМЕТРИЙН 5 ХОНОГИЙН АЯЛАЛЫН ЗАРДАЛ

Д/д	Төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нэг хоногийн нийт үнэ /төг/	Нийт үнэ 5 хоногоор /төг/
1	Машины түрээс /жийп/	6	377 000	2 262 000	2 262 000
2	Машины түрээс /пургон/	2	70 000	140 000	700 000
3	Шатахуун	8 машин	122 200	977 600	4 888 000
4	Хоол	30 хүн	60 000	1 800 000	9 000 000
5	Зочид буудал	1 хононо	1 200 000	1 200 000	1 200 000
6	Амралтын газар	5 гэр /1хононо/	65 000	325 000	325 000
7	Бэлэг дурсгал	25	25 000	-	625 000
Нийт					19 000 000

-oOo-